



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2016 оны 10 сарын 04 өдөр

Дугаар 114

Эрдэнэт

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны үндсэн журмын 16.1 дэх заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. "Аймгийн ИТХ-ын шагналын журам"-ын 2.4.2 дахь заалтын Аймгийн ИТХ-ын шагнал "Иргэний төлөө медаль"-иар тус аймагт 10-аас доошгүй жил ажиллаж ...гэснийг 15 жил, "Аймгийн ИТХ-ын шагналын дагалдах мөнгөн шагналыг Хурлын байгууллагын шийдвэр, тодорхойлсон байгууллагын саналыг тус тус үндэслэн тухайн байгууллагаас гаргуулж болно" гэж 2.5 дахь заалт болгон нэмж, тус тус өөрчлөлт оруулан баталсугай.

2. Аймгийн ИТХ-ын шагналын журманд оруулсан өөрчлөлтийг олон нийтэд мэдээлэх, мөрдөж ажиллахыг аймгийн ИТХ-ын дарга П.Пүрэвлхагвад даалгасугай.

ДАРГА



П.ПҮРЭВЛХАГВА